



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/70

Арвайхээр сум

Улсын бүртгэлийн хэлтсийг нүүлгэн шилжүүлэхэд  
авах зарим арга хэмжээний тухай

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/03 дугаар тогтоолоор батлагдсан “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.3.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн албаны нууцад хамаарах, төрөлжсөн архивын баримт, мэдээллийн сан бүхий тоног төхөөрөмжийг одоо байгаа байрнаас хуучин цагдаагийн байранд нүүлгэн шилжүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, байрны засвар үйлчилгээ болон нүүлгэн шилжүүлэхтэй холбогдон гарах зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Нүүлгэн шилжүүлэхтэй холбогдсон арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, явуулахыг аймгийн Засаг даргын тамгын газар (Ц.Ганболд), аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Цэдмаа)-т тус тус даалгасугай.

3. Дээрх ажилд зарцуулагдах 21,858,860 (хорин нэгэн сая найман зуун тавин найман мянга найман зуун жаран) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0087

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны  
...дүгээр сарын ...-ны өдрийн  
...дугаар захирамжийн  
...дүгээр хавсралт

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН АЛБАНЫ НУУЦЫН ЗЭРЭГЛЭЛТЭЙ  
ТӨРӨЛЖСӨН АРХИВ, МЭДЭЭЛЛИЙН САН БҮХИЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ  
НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Ганболд (аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд:

Ч.Ууганбаяр (Тагнуулын ерөнхий газрын Өвөрхангай аймаг дахь хэлтсийн Мэдээллийн аюулгүй байдлын ажилтан) зөвшилцснөөр

Х.Батпүрэв (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн хошууч)

Г.Ариунаа (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Орон нутгийн өмчийн газрын Өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан мэргэжилтэн)

Д.Баярмөнх (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Улсын бүртгэлийн хэлтсийн ахлах нягтлан бодогч)

Л.Отгонболд (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Улсын хэлтсийн мэдээлэл технологийн ажилтан)

Нарийн бичгийн дарга: Б.Цэдмаа (аймгийн засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга)

-оОо-

Аймгийн Засаг даргын 2023 оны  
 ..... дүгээр сарын .....-ны өдрийн  
 ..... дугаар захирамжийн  
 ..... дугаар хавсралт

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН АЛБАНЫ НУУЦЫН ЗЭРЭГЛЭЛТЭЙ  
 ТӨРӨЛЖСӨН АРХИВ, МЭДЭЭЛЛИЙН САН БҮХИЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ НҮҮЛГЭН  
 ШИЛЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ

д/д	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)	Тайлбар
1	<b>Тээвэр, шатахууны зардал</b>				
	Түлш	249 литр	4020	1,000,980	нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний дагуу бүхээгтэй машинд 20 хайрцаг буюу, 50 хадгаламжийн нэгж 1000 хувийн хэрэг зөөхөөр тусгагдсан мөн тээврийн хөлс багтсан. Зөөгдөх нийт хувийн хэрэгийн тоо 150,000 рейсийн тоо 150 удаа
2	<b>Тоног төхөөрөмж материалын шаардлага</b>				
	Шилэн кабель сүлжээний зардал	400 метр	3500	1,400,000	УБХ-ийн сервэрийг нүүлгэн шилжүүлэх, МХС-ын байрнаас цагдаагийн байр хооронд сувагчлалаар татах, ТҮНТөв рүү татахтай холбоотой зардал
	Шилэн кабель татах ажлын хөлс	400 метр	2500	1,000,000	Агаараар шилэн кабель шинээр татах
	УТР кабель утасны зардал	600 метр	1500	900,000	Дотоод сүлжээний кабел бүх өрөө тасалгаанд оруулж, камер, дохиоллын utp кабель (сүлжээний утас) тус бүрт татах
	Сүлжээний свич бусад хэрэгсэл	3	300,000	900,000	Хямд свич шаардлага хангахгүй болно 16 порттой свич
	Камержуулалт	10 ширхэг	160,000	1,600,000	Нийт 16 камер суурилуулахаас 6 ширхэг хэрэглэж байгаа
	Шинэ байрны 1 давхрын архив байрлах 8 өрөөний цонхонд гадна хамгаалалт	8 цонх	107.500	860.000	Одоогоор 2 цонх төмөр хамгаалалттай байгаа. Архив болон үйлчилгээний зааланд нэмж 8 цонхонд материалыг нь авч өгч

	хийлгэх				гагнуулна.
	Үйлчлүүлэгчийн хүлээлгийн сандал худалдан авах	4 ширхэг	975,000	3,900,000	Үйлчлүүлэгчийн хүлээлгийн сандал худалдан авах
	Үйлчилгээний заалны 4 цонх засварлуулах	4 цонх	200,000	800,000	Цонхны бариул, резин сольж цилкон шахаж дулаалах хагархай 2 цонхны шил солих
	Вакум хаалт	1 хаалт	1,600,000	1,600,000	Байрны 1 давхарт архив тусгаарласан хаалга хийлгэх
	Гэрэлтүүлэг	20	60,000	1,200,000	Үйлчилгээний зааланд дөрвөлжин лед гэрэл, 1,2 давхарын коридиорын гэрэл, гадна гэрэлтүүлэг солих
	Дохиолол	Дуу чимээ мэдрэгч-20, Хөдөлгөөн мэдрэгч-20, Утаа мэдрэгч-20, станц-1	70,000 70,000 60,000 1,400,000	5,400,000	Тус байр нь дохиоллын систем байхгүй, шинээр суурилуулна.
3	Шинэ байрны засвар үйлчилгээ	-	1,297,880	1,297,880	Өрөөнүүдийн тааз хананд эмульс хийх, паркетан шал шахаж засварлах, үйлчилгээний залны цонхны тавцан засварлах
	Нийт зардал	-	-	21,858,860	